



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/304

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.21 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дах хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Өсвөр үеийн клиник, кабинетын үлгэрчилсэн дүрэм”-ийг хоёрдугаар, “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц”-ыг гуравдугаар, “Өсвөр үеийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ж.Отгонбаатар), тайланг нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа), Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар (Л.Баттөр)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” А/399 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141242352

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 9 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Өсвөр үеийнхний бие махбод, сэтгэлзүй, нийгмийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.3. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх стандарт болон бусад дагалдах дүрэм, журам, зааврыг баримтална.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

- 2.1. Өсвөр үе: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тодорхойлсноор 10-19 насыг;
- 2.2. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ: Өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй, тохиромжтой, нууцыг хадгалсан тусламж, үйлчилгээг;
- 2.3. Өсвөр үеийнхэнд мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх нэгж: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй багаар үзүүлэх кабинет, клиникийг;

Гурав. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

- 3.1. Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн ээлтэй тусламж, үйлчилгээнд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1. ээлтэй, хүний эрхийг дээдлэх
 - 3.1.2. тэгш, хүртээмжтэй
 - 3.1.3. хувь хүний нууцыг хадгалах
 - 3.1.4. жендерийн тэгш байдлыг хангах
 - 3.1.5. хэнийг ч орхигдуулахгүй байх

Дөрөв. Үйл ажиллагааны зохион байгуулалт

- 4.1. Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дараах эрүүл мэндийн байгууллагуудын оролцоотой байна. Үүнд:
 - 4.1.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага
 - 4.1.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв
 - 4.1.3. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
 - 4.1.4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
 - 4.1.5. Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-2
 - 4.1.6. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
 - 4.1.7. Халдварт өвчин судлалын үндэсний төв
 - 4.1.8. Амгалан, Өргөө, Хүрээ амаржих газар
 - 4.1.9. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
 - 4.1.10. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг
 - 4.1.11. Нийслэлийн дүүргийн эрүүл мэндийн төв
 - 4.1.12. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв
 - 4.1.13. Хувийн хэвшлийн эмнэлэг, клиник

Тав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага

- 5.1. Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах хэлбэртэй байна. Үүнд:
 - 5.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
 - 5.1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- 5.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь өсвөр үеийнхнийг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалах, эрүүл, аюулгүй суралцах, амьдрах орчин бүрдүүлэхэд хувь хүн, үе тэнгийнхэн, тэдний гэр бүл, олон нийт, салбар хоорондын хамтын ажиллагааг хангасан цогц арга хэмжээнд чиглэнэ.
- 5.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь өсвөр үеийнхэнд тохиолдох биеийн болон сэтгэцийн өвчин эмгэгийг оношилж, эмчлэх, хянахад чиглэнэ.
- 5.4. Өсвөр үеийнхэнд үзүүлсэн нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын бүртгэлийн журмын дагуу холбогдох байгууллагуудад мэдээллийг хугацаанд нь өгнө.
- 5.5. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ангилж, яаралтай болон тулгамдсан шинжийг шалган, холбогдох эмнэлзүйн удирдамж, журам, зааврын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 5.6. Архаг, суурь эмгэгтэй өсвөр үеийнхнийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулж, асран хамгаалагч болон өөрт нь өвчний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, эрүүл мэндийг нь дэмжиж, амьдралын чанарыг нь сайжруулна.

- 5.7. Аливаа хүчирхийлэлд өртөх эрсдэлийг үйлчлүүлэгч бүрт нягтлан шалгаж, өртсөн тохиолдолд зохих арга хэмжээг авна.
- 5.8. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг цаг алдалгүй шилжүүлж, шилжүүлэхтэй холбоотой мэдээллээр хангана.
- 5.9. Эрүүл мэндийн байгууллага хооронд онош тодруулахаар хүүхдийг илгээх тохиолдолд эмч, мэргэжилтнүүд мэдээлэл солилцож, эргэн мэдээлэлтэй ажиллана.
- 5.10. Өсвөр үеийн хүүхэд, түүний асран хамгаалагчдад оношилгоо, эмчилгээний талаар мэдээлэл өгч, шийдвэр гаргалтад оролцох, хүүхдийн насыг харгалзан таниулсан зөвшөөрөл өгөх, сонголт хийх боломжийг олгоно.
- 5.11. Өсвөр үеийн үйлчлүүлэгч бүрт өвдөлт болон стрессийн шинж тэмдгийг үнэлж, зохих удирдамж, зааврын дагуу тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 5.12. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, дотоод хяналтын алба, ёс зүйн баг, дэд хороо нь өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэхэд онцгой анхаарах хандуулж, харилцаа, хандлагын доголдол гаргахаас урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- 5.13. Эрүүл мэндийн байгууллага нь өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулах нөхцөл бүрдүүлж, шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, ээлтэй орчин бий болгоно.

Зургаа. Эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг

6.1. Төрийн захиргааны төв байгууллага

- 6.1.1. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтвортой байдал, чанар, хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчноор хангана.
- 6.1.2. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн чиглэлээр хийгдэх эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.

6.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв

- 6.2.1. Өсвөр үеийн эмч, мэргэжилтэн бэлтгэх төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн болон багц цаг, баримжаа олгох сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 6.2.2. Үндэсний хэмжээнд өсвөр үеийн эмч, мэргэжилтний хүртээмжид дүн шинжилгээ хийх, эмнэлгийн мэргэжилтнүүдэд өсвөр үеийнхэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудал, баримтлах зарчим, харилцаа хандлагын талаарх агуулгыг төгсөлтийн дараах сургалтад тусгах, сургалтын чанарт хяналт тавина.

6.2.3. Эрүүл мэндийн байгууллагын жилийн тайлангийн нэгтгэлд статистик боловсруулалт хийж, эрүүл мэндийн салбарын үндэсний хэмжээнд гаргах үзүүлэлтийг тооцож, дүгнэлт хийн, эмхэтгэл болгон хэвлүүлж, Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн хороо болон холбогдох бусад байгууллага, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт дараа жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

6.3. Төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг

- 6.3.1. Чиг үүргээсээ хамааран эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг өсвөр үе, тэдний арсан хамгаалагчдад багаар үзүүлнэ.
- 6.3.2. Өсвөр үеийнхэнд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлзүйн заавар, удирдамжийг олон улсын жишигт нийцүүлэхэд чиглэсэн өөрчлөлт, шинэчлэлийг тусган боловсруулна.
- 6.3.3. Өсвөр үеийнхэнд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангана.
- 6.3.4. Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран өсвөр үеийнхний эрүүл мэнд, өвчлөл, нийгэм-сэтгэлзүйн асуудал, эрүүл мэндийг тодорхойлогч нийгмийн хүчин зүйлсийг тандан судална.
- 6.3.5. Өсвөр үеийнхний эрүүл мэндийг сайжруулах, тулгамдаж буй асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэнэ.
- 6.3.7. Өсвөр үеийн охидын жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж үйлчилгээ, гэр бүл төлөвлөлт болон нийгэм- сэтгэлзүйн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 6.3.8. Өсвөр үеийнхний сайн сайхан байдал, эрүүл мэндийг дэмжих, сайжруулах чиглэлээр боловсролын байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллана.
- 6.3.9. Өсвөр үеийнхэн, тэдний асран хамгаалагчдад эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, арга хэмжээг зохион байгуулна.

6.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

- 6.4.1. Харьяалах эрүүл мэндийн байгууллагуудыг өсвөр үеийнхэнд хүртээмжтэй, чанартай, аюулгүй байдлыг хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ээлтэй орчинд үзүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангана.
- 6.4.2. Урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг зохион байгуулж, өсвөр үеийнхний эрүүл мэндийн статистик мэдээлэл дээр үндэслэн хариу арга хэмжээний зорилтот хөтөлбөрийг гарган, хэрэгжилтийг хангана.
- 6.4.3. Өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг төр, хувийн хэвшлийн эрүүл

мэндийн байгууллагуудын оролцоотой зохион байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, мэдээлэх, хянах арга хэмжээг авна.

6.5. Амаржих газар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв

- 6.5.1. Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх кабинетыг тусгайлан байгуулна.
- 6.5.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд өсвөр үеийн үйлчлүүлэгчид зориулсан хэвтэн эмчлүүлэх орыг хүн амын тоонд харгалзан гаргаж, бэлэн байдлыг хангах.
- 6.5.3. Өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг оношлох, эмчлэх, шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт илгээх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, мэдээлэх, хянах үйл ажиллагааг өсвөр үеийн төрөлжсөн мэргэшлийн эмч, уламжлалт анагаах ухааны эмч, сувилагч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан хамтран зохион байгуулна.
- 6.5.4. Өсвөр үеийнхний бие, хэл, сэтгэлийн үйлийг эрүүл байлгахад чиглэсэн уламжлалт анагаах ухааны идээ, унд, явдал мөр, эм, заслын аргаар эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчнийг хянаж, хүндрэлээс сэргийлэх зорилгоор үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж, зөвлөгөө, мэдээлэл өгнө.
- 6.5.5. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ боловсролын болон аж ахуй нэгж байгууллагатай хамтран өсвөр үеийнхэн, тэдний гэр бүлийн гишүүдэд өсвөр үеийн онцлогт нийцсэн зөв, идэвхтэй амьдралын дадал хэвшлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа, ухуулга, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулна.

6.6. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв

- 6.6.1. Үйлчлэх хүрээний өсвөр үеийнхний бүртгэл судалгааг жил тутам шинэчилж, эрүүл мэндийн бүлэгт ангилан, өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг хяналтад авч ажиллана.
- 6.6.2. Өсвөр үеийнхнийг дархлаажуулах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг дангаар болон мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулна.
- 6.6.2. Өсвөр үеийнхэнд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулна.
- 6.6.3. Өсвөр үеийнхний эрүүл мэндэд нөлөөлж байгаа зан үйл, эрсдэлт хүчин зүйлийг судлах, үнэлэх, тандах, хянаж, дүнг мэдээлнэ.

6.7. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

- 6.7.1. Өсвөр үеийн насны үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тус журмын 5 дугаар бүлэгт дурдсан ерөнхий шаардлагыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 6.7.2. Аливаа хүчирхийлэлд өртөх эрсдэлийг үйлчлүүлэгч бүрд нягтлан шалгаж, өртсөн тохиолдолд зохих арга хэмжээг шуурхай авна.

Долоо. Хяналт, үнэлгээ

- 7.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв нь харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн тусламж, үйлчилгээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.
- 7.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудалд жилд 1 удаа хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.
- 7.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар жилд нэгээс доошгүй удаа, харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудалд үнэлгээ хийнэ.
- 7.4. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудалд үнэлэлт, дүгнэлт хийж, зөвлөмж өгнө.



Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн 11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ӨСВӨР ҮЕИЙН КЛИНИК, КАБИНЕТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Клиник, кабинетын үйл ажиллагааны үндсэн зарчим

- 1.1. Клиник, кабинет нь өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дор дурдсан үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:
 - 1.1.1. өсвөр үеийнхний эрх ашиг, хүний эрхийг дээдлэх
 - 1.1.2. жендерийн тэгш байдлыг хангаж ажиллах
 - 1.1.3. хувийн нууцыг хадгалах
 - 1.1.4. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад ээлтэй байх
 - 1.1.5. үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх
 - 1.1.6. өсвөр үеийнхний оролцоонд тулгуурлах

Хоёр. Бүтэц, зохион байгуулалт

- 2.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт өсвөр үеийн эрүүл мэндийн клиник, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, амаржих газруудад өсвөр үеийн кабинет ажиллана.
- 2.2. Хувийн хэвшлийн эмнэлэг өсвөр үеийн кабинет эсвэл клиник хэлбэрээр ажиллаж болно.
- 2.3. Төр болон хувийн хэвшлийн өсвөр үеийн клиник, кабинетын үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагууд өсвөр үеийн эмч, мэргэжилтнүүдийн тасралтгүй сургалтыг хангаж ажиллана.

Гурав. Өсвөр үеийн эрүүл мэндийн клиникийн ерөнхий шаардлага

- 3.1. Өсвөр үеийн эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйчийн (харъяалах хүн амын тооноос хамаарч орон тооны бус байж болно) бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.
- 3.2. Өсвөр үеийнхэнд чанартай эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тавилга, компьютер, интернэтийн сүлжээ, ном товхимол болон бусад хэрэгцээт зүйлээр бүрэн хангагдсан байна.
- 3.3. Клиник нь тусгайлан үзлэг хийх өрөө, зөвлөгөө өгөх/сэтгэлзүйчийн ярилцлага хийх өрөө, өдрийн эмчилгээний өрөө, ганцаарчилсан болон бүлгийн сургалтын өрөө, хүлээлгийн хэсэг, ариун цэврийн өрөөтэй байна.
- 3.4. Өсвөр үеийн үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн ажлын цагийн зохицуулалтыг журамлан, хэрэгжүүлдэг байна.
- 3.5. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн талаар мэдээллийн сан үүсгэн,

баяжилтыг тогтмол хийнэ.

- 3.6. Өсвөр үеийн үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлсэн, өвөрмөц хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны цахим болон биет хэрэгсэлтэй, баяжилт, шинэчлэлийг тогтмол хийдэг байна.
- 3.7. Утсаар эсвэл цахимаар үзлэгийн цаг захиалах, зөвлөгөө авах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Дөрөв. Клиникийн үйл ажиллагааны чиглэл

- 4.1. Өсвөр үеийн эрүүл мэндийн талаар нотолгоонд тулгуурласан мэдээллийн багц бэлтгэн, өсвөр үеийнхэн болон тэдний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулна.
- 4.2. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлаар боловсрол, нийгмийн хамгааллын болон бусад салбарынхантай хамтран ажиллан, салбар хоорондын хамтын ажиллагааг хангаж ажиллана.
- 4.3. Клиникийн үйл ажиллагааны тайланг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор цахимаар мэдээлнэ.
- 4.4. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн чиглэлээр тулгамдаж байгаа асуудлын талаар судалгаа хийж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдыг нотолгоонд түшиглэсэн мэдээллээр хангаж ажиллана.
- 4.5. Эмнэлзүйн удирдамж, заавар, зөвлөмж боловсруулж, эмч, мэргэжилтэнд тасралтгүй сургалт хийн, мэдлэг, мэдээллийг нь нэмэгдүүлнэ.
- 4.6. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, амаржих газрын өсвөр үеийн эрүүл мэндийн кабинетын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.
- 4.7. Жирэмслэлт, Төрөлт, үр хөндөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг багаар хамтран үзүүлнэ.

Тав. Кабинетын ерөнхий шаардлага

- 5.1. Кабинет нь өсвөр үеийн эмч (өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр давтан сургалтад тогтмол хамрагддаг, эсвэл баримжаа олгох сургалтад хамрагдсан хүүхдийн эмч байж болно), нийгмийн ажилтан болон сэтгэл зүйч/зөвлөх (харъяалах хүн амын тооноос хамаарч орон тооны бус байж болно)-ийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.
- 5.2. Кабинетын нийгмийн ажилтнаар өсвөр үеийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтан эсхүл сувилагч, бага эмч ажиллаж болно.
- 5.3. Өсвөр үеийнхэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тавилга, компьютер, интернэт, ном товхимол болон бусад хэрэгцээт зүйлээр бүрэн хангагдсан байна.
- 5.4. Кабинет нь үзлэгийн өрөө, зөвлөгөө өгөх өрөө, сургалтын өрөө, хүлээлгийн хэсэг, ариун цэврийн өрөөтэй байна.

- 5.5. Өсвөр үеийнхэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг удаагийн үзлэгийн багаж, эм хэрэгслээр хангагдсан байна.
- 5.6. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн талаар мэдээллийн сан үүсгэн, баяжилтыг тогтмол хийнэ.
- 5.7. Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээний байдалд тогтмол үнэлгээ, судалгаа хийж, шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг алдалгүй зохион байгуулна.
- 5.8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийг чанд баримтлан ажиллана.

Зургаа. Кабинетын үйл ажиллагааны чиглэл

- 6.1. Өсвөр үеийн эрүүл мэндийн талаар лавлагаа мэдээллийн багц бэлтгэн, өсвөр үеийнхэн болон тэдний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулна.
- 6.2. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмчлэн эрүүлжүүлж, зөвлөгөө өгч ажиллана.
- 6.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, өсвөр үеийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
- 6.4. Кабинетын үйл ажиллагааны тайланг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор цахимаар мэдээлнэ.

Долоо. Клиник, кабинетын ажиллах бүрэлдэхүүний ажил үүргийн хуваарь

- 7.1. Өсвөр үеийн эрүүл мэндийн клиник, кабинетын эмч нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 7.1.1. өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;
 - 7.1.2. өсвөр үеийн хүүхдийн сэтгэц, нийгмийн байдлыг үнэлж, эрсдэлтэй зан үйлийг илрүүлэх;
 - 7.1.3. өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
 - 7.1.4. үе тэнгийн зөвлөгчдийг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран бэлтгэх төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх;
 - 7.1.5. төрийн болон төрийн бус байгууллагатай өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлаар хамтран ажиллах;
 - 7.1.6. эрүүл мэндийн бусад байгууллага, сургуультай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
 - 7.1.7. өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулах;
 - 7.1.8. өсвөр үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ эх барих,

эмэгтэйчүүдийн эмч, БЗДХ, лабораторийн болон бусад төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллах;

7.1.9.үйлчлүүлэгчийг шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт илгээх, шилжүүлэх, хяналт тавих;

7.2. Нийгмийн ажилтан нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.2.1.үйлчлүүлэгчийн нийгэм, сэтгэлзүйн эрсдэлийг үнэлж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамран ажиллаж, шаардлагатай тохиолдолд сэтгэц, нийгмийн тусламж, үйлчилгээнд чиглүүлэх, хяналт тавих;

7.2.2. хүүхэд хамгааллын хамтарсан багтай хамтарч ажиллах;

7.2.3.харъяалах хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тандан судлах, эмч, төр, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай хамтран шаардлагатай хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

7.2.4.кабинетын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ, мэдээллийг энэ журамд заасны дагуу холбогдох байгууллагуудад мэдээлэх;

7.2.4.үйлчлүүлэгч, түүний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;

7.2.5.өсвөр үеийнхний эрүүл мэндийн талаар батлагдсан хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд эмчтэй хамтран ажиллаж, мэдээлэл сургалт сурталчилгаа явуулах;

7.2.6.үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, баяжилтыг жил бүр хийх;

7.3. Сэтгэл зүйч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.3.1.өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн оношилгоо хийх, зөвлөгөө өгөх, эрсдэлтэй зан үйлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авх тусламж, үйлчилгээ үзүүлэх;

7.3.2.үйлчлүүлэгчдийг хяналтад авах, шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлэх, хяналт тавих;

7.3.3.үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж, мэдээлэхэд эмч, нийгмийн ажилтантай хамтран ажиллах;

7.3.4.өсвөр үеийн хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт зориулан сэтгэцийн эрүүл мэндийн ганцаарчилсан болон бүлгийн сургалт зохион байгуулах, олон нийтэд хандсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах;

Найм. Клиник, кабинетын ажиллах үлгэрчилсэн цагийн хуваарь

8.1. Даваа гарагаас Баасан гарагт буюу ажлын 5 өдөр, найман цагаар ажиллана.

8.2. Ажлын цагийн хуваарийг үйлчлүүлэгчдэд ил тод байрлуулах ба өсвөр үеийнхэн олноор цугладаг сургууль, дотуур байр зэрэг газруудад байршуулж болно.

8.3. Орон нутгийн онцлог, үйлчлүүлэгчдэд тохирсон уян хатан цагийн хуваарьтай байж болох ба цагийн хуваарийг тухайн байгууллагын даргаар баталгаажуулан мөрдөнө.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 9/2024 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ӨСВӨР ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ

Тусламж, үйлчилгээний төрөл	Өрх, сум, тосгоны ЭМТ	БОЭТ, Нэгдсэн эмнэлэг	Дүүргийн ЭМТ	Амаржих газар	Төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг
1. Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
Асуумж ярилцлага	+	+	+	+	+
Биеийн ерөнхий үзлэг	+	+	+	+	+
Сэтгэц-нийгмийн үнэлгээ (НЭЕАDSSSS үнэлгээ)	+	+	+	+	+
Бэлгийн бойжлын үнэлгээ	+	+	+	+	+
Өсөлтийн үнэлгээ	+	+	+	+	+
Нөхөн үржихүйн эрхтний тусгайлсан үзлэг	-	+	+	+	+
Лабораторийн болон үйл оношийн шинжилгээ	+	+	+	+	+
ДОХ/ХДХВ, БЗДХ-ын сайн дурын үзлэг, сорил, шинжилгээ	+	+	+	+	+
Жирэмснийг оношлох	+	+	+	+	+
Үр хөндөлтийн өмнөх тусламж үйлчилгээ	+	+	+	+	+
Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ	-	-	+	+	+
Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн тусламж үйлчилгээ	+	+	+	+	+
Хүчирхийллийн хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээ	+	+	+	+	+
Жирэмсний хяналт	+	+	+	+	+
Төрөлтийн тусламж үйлчилгээ	-	-	+	-	+
Төрсний дараах тусламж, үйлчилгээ	+	+	+	+	+
Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны эмгэг	+	+	+	+	+

илрүүлэх тусламж үйлчилгээ					
Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	-	+	+	-	+
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ					
Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ	-	+	+	+	+
Эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх	+	+	+	+	+
“Үе тэнгийн сургагч бэлтгэх”	+	+	+	-	-
Сургуулийн эмч нартай хамтран ажиллах	+	+	+	+	-
Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ	+	+	+	+	+
Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдэд өсвөр үе, оюутан залуучуудын дунд сургалт, сурталчилгаа зохион байгуулах	+	+	+	+	+
Олон нийтэд түшиглэсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	+	+	+	-	-
Сургуульд суурилсан хөтөлбөрөөр дамжуулан эрүүл мэндийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх	+	-	+	-	-
“Хамтарсан баг”-ийн тусламж, үйлчилгээ	+	+	+	-	+
Уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө мэдээлэл	+	+	+	+	+

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 18
дугаар сарын 11-ны өдрийн 18 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**ӨСВӨР ҮЕИЙН КЛИНИК, КАБИНЕТЫН ИХ ЭМЧИЙН АЛБАН ТУШААЛЫН
ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03
дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо: 2024

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

.....

Албан тушаалын нэр:

Өсвөр үеийн их эмч

Ажлын цаг:

8

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

.....

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Засгийн газрын тогтоолд зааснаар

Ажлын байрны албан ёсны байршил:

.....

Онцгой нөхцөл:

.....

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Өсвөр үеийнхэнд нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж, үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалахад чиглэнэ.

Албан тушаалын зорилт:

1. Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн ээлтэй цогц тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх
2. Өсвөр үеийнхэн, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх дадал хэвшлийг эзэмшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, сургуулийн эмч, эмнэлгийн эмч, мэргэжилтний уялдаа холбоо болон салбар дундын хамтын ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж ажиллах
3. Өсвөр үеийн эрүүл мэнд болон мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдаж мэдлэг, мэдээллээ тогтмол дээшлүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> Өсвөр үеийнхэн, залуучуудын хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн ээлтэй цогц тусламж үйлчилгээг үзүүлэх, оношилгоо эмчилгээний түгээмэл үйлдлийн стандартыг мөрдлөг болгон ажиллах Шаардлагатай тохиолдолд эмчилгээ үйлчилгээг зохих журмын дагуу дараагийн шатны тусламж, үйлчилгээнд шилжүүлэх ба эрүүл мэндийн тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгч ажиллах Өсвөр үеийнхэн, залуучуудын өвчлөлийн үзүүлэлтэд судалгаа, дүгнэлт хийж, тусламж үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах талаар санал дэвшүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах 	Ажлын гүйцэтгэл	Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х
2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> Өсвөр үеийн клиник, кабинетын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах Өсвөр үеийнхэн, залуучуудын дунд зонхилох өвчлөл болон зан үйлийн байдалд үнэлэлт өгч, судалгаа шинжилгээнд үндэслэсэн бүтээлч, шинэлэг үйл ажиллагааг эрчимжүүлэх Сургуулийн эмч нарыг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай холбон ажиллаж оюутан, сурагчдыг шаардлагатай тусламж, үйлчилгээнд илгээх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах Ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын эмч, багш нарын эрүүл мэндийг хамгаалах талаар нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөн, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллах 	Ажлын гүйцэтгэл, оролцсон арга хэмжээ	Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х
3 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> Төр болон төрийн бус байгууллагуудтай өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудлаар хамтран ажиллах "Үе тэнгийн сургагч" бэлтгэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн сурагч нарт хийж, хүүхэд хүүхдэдээ нөлөөлөх ажлыг дэмжин ажиллах Мэргэжил мэдлэг, ур чадвар, мэргэшлийг байнга дээшлүүлэх сургалтад тогтмол хамрагдах 	Ажлын гүйцэтгэл	Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Анагаах ухааны бакалавраас доошгүй зэрэгтэй
Мэргэжил	Хүүхдийн анагаах ухаан
Мэргэшил	Төгсөлтийн дараах өсвөр үеийн анагаах ухааны чиглэлээр мэргэшсэн байх
Туршлага	Эрүүл мэндийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Албан хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах - Бусад

		<ul style="list-style-type: none"> - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг - Бүтээлч, санаачилгатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг чанд баримтлан харилцааны соёлыг эрхэмлэх - Мэргэжлийн зөвлөгөө өгөх ур чадвартай - Бүтээлч сэтгэлгээ, хариуцлага хүлээх чадвартай - Хувь хүний нууц хадгалах - Бусад
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах - Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх - Байгууллагын зорилго, үйл ажиллагааг ойлгох хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах - Мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах - Хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх - Бусад

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Байгууллагын дарга, удирдах ажилтан

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <p>Нэр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Өсвөр үеийн клиник, кабинетын сувилагч 2. Нийгмийн ажилтан 	<p>Бусад харилцах субъект</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгч, түүний ар гэр, асран хамгаалагч 2. Ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, эмч нар 3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага 4. Мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоод 5. Төр болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, бусад 6. Бусад төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн
--	---

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<p>Албан тушаал:</p> <p>202... оны.....дугаар сарын.....-ны өдөр</p>	<p>Албан тушаал:</p> <p>Өсвөр үеийн клиник, кабинетын эмч/эмчийн нэр/ 202... оны.....дугаар сарын.....-ны өдөр</p>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<p>Албан тушаал:</p> <p style="text-align: center;">..... ЭМНЭЛГИЙН ДАРГА/ ЗАХИРАЛ</p> <p>..... /нэр/ (гарын үсэг)</p> <p>202.. оны..... дугаар сарын-ны өдөр</p>	